



**НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
УЛААНБААТАР НЭГТГЭЛ ОНӨААТҮГ
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2016 оны 04 сарын 18 өдөр

Дугаар А/32


Улаанбаатар хот

Хөрөнгө зарцуулах тухай

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэг, Засгийн газрын 2015 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн "Дүрэм шинэчлэн батлах тухай" 269 дүгээр тогтоолоор батлагдсан "Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм"-ийн 1.5 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1 дэх заалт, 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2013 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 100 дугаар тогтоолоор батлагдсан "Нийтийн үйлчилгээний Улаанбаатар нэгтгэл" ОНӨААТҮГ-ын дүрмийн 6.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аж ахуйн нэгж байгууллагын хүлээсэн үүргийн дагуу 2016 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр үйлдвэрлэлийн осолд орсон Үйл ажиллагаа дэмжих асуудал хариуцсан Орлогч дарга С.Майнбаяр, Баруун салбарын авто баазын Аж ахуйн үйлчилгээний жолооч Д.Хатанбаатар нарын эмнэлгийн анхан шатны үзлэг шинжилгээний зардалд шаардагдах хөрөнгийг хавсралтаар баталсугай.
2. Дээрх зардалд шаардагдах 652 375 /Зургаан зуун тавин хоёр мянга гурван зуун далан таван/ төгрөгийг хөрөнгийг өөрийн орлогоос тооцон гаргахыг Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч Д.Мөнх-Эрдэнэд зөвшөөрсүгэй.
3. Ажилтнуудыг эмнэлэгт хүргэх болон бусад шаардлагатай арга хэмжээг түргэн шуурхай зохион байгуулж ажиллахыг Ерөнхий инженер бөгөөд Шуурхай удирдлагын төвийн дарга /С.Баяр-Өлзий/ болон Үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэх, шалтгааныг тогтоох, дүгнэлт гаргах орон тооны бус байнгын комиссын гишүүдэд даалгасугай.
4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хүний нөөцийн удирдлагын хэлтсийн дарга /М.Зундуйдаваа/-д үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Д.ЭНХСАЙХАН

D:\A tushaal.docx

2100000063